

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ХӨТӨЛБӨРИЙН 2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА**

2023.06.09

Булган аймаг

**Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, үндэслэл, арга зүй**


Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны XIII хуралдааны XIII/02 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны “Шинэ хөгжлийн зам” хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2023 оны А/138 дугаар захирамжаар хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тус тус өөрчлөлт оруулан шинэчлэн баталсан. Тус хөтөлбөр, төлөвлөгөөний зорилт, арга хэмжээ, зорилтот түвшнийг 2023 оны эхний хагас жилийн хэрэгжилттэй харьцуулан тооцож, үр дүнг үнэлэн, дүгнэлт өгч, удирдлагыг үнэн бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх, гүйцэтгэл, үр дүнг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор нэмэлт өөрчлөлт орсон “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 3б хавсралтын дагуу гаргасан тайланд бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг тооцох аргачлалын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

**Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн**

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 бүлэг, 102 зорилтын хэрэгжилтэд 2023 оны эхний хагас жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд зорилтын хэрэгжилт 61.1 хувь буюу “эрчимжүүлэх шаардлагатай” байна.

Хүний хөгжлийн бодлогын 29 зорилт 65.1 хувь, эдийн засгийн бодлогын 22 зорилт 68.1 хувь, ногоон хөгжлийн бодлогын 22 зорилт 52.0 хувь, засаглалын бодлогын 19 зорилт 72.9 хувь, бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын 10 зорилт 47.5 хувьтай хэрэгжсэн байна. Үүнд 7 зорилт 100 хувь буюу үр дүнтэй, 38 зорилт 70.0-100 хүртэл хувь буюу тодорхой үр дүнд хүрсэн, 53 зорилт 30.0-70.0 хүртэл хувь буюу эрчимжүүлэх шаардлагатай, 4 зорилт 0-30.0 хүртэл хувь буюу үр дүнгүй байна. Харин 1 зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээг 2024 оноос хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөгөөндөө тусгасан тул үнэлгээнд оруулж тооцоогүй болно.



Тус хөтөлбөрийн 12 зорилтын хэрэгжилт 0-30.0 хувийн хэрэгжилттэй байгаа ба энэхүү зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн хүрээнд бэлтгэл ажил хийгдсэн, дээд шатны байгууллагад хүсэлтээ уламжилсан боловч хөрөнгийн асуудал шийдвэрлэгдээгүй, Засгийн газрын шийдвэрээр тендер сонгон шалгаруулалтыг түр зогсоосон зэргээс шалтгаалан хэрэгжилт нь удааширчээ.

Дээрх 102 зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 233 арга хэмжээнээс 40 арга хэмжээ 100 хувь, 18 арга хэмжээ 90.0 хувь, 63 арга хэмжээ 70.0 хувь, 60 арга хэмжээ 50.0 хувь, 44 арга хэмжээ 30.0 хувь, 7 арга хэмжээ 0 хувь, 1 арга хэмжээ 75.0 хувийн хэрэгжилттэй байна. Харин 26 арга хэмжээ өмнөх жилүүдэд хэрэгжсэн болон ирэх онд хэрэгжэхээр төлөвлөгөөнд туссан байна.

Энэхүү төлөвлөгөөнөөс тухайн арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангасан болон ажлын гүйцэтгэлээр нь 44 арга хэмжээг 30.0 хувиар, тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг авч эхэлж байгаа эсвэл хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй 7 арга хэмжээг 0 хувиар тус тус дүгнэлээ. Хөрөнгийн эх үүсвэргүй, холбогдох байгууллагын шийдвэр гараагүй байгаа зэрэг шалтгаанаас зарим арга хэмжээний хэрэгжилт удаашралтай байна.

Тухайлбал дээрх хэрэгжилт нь удаашралтай арга хэмжээнүүдээс 7 нь оны сүүлийн хагаст хэрэгжих, 18 нь төсөв хөрөнгөгүй, 4 арга хэмжээ нь удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ аваагүй, бусад байгууллагын шийдвэр гараагүй зэргээс хамаарчээ. Харин 22 арга хэмжээний холбогдох бэлтгэл ажлыг хангаж, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж байна.

## **Гурав. Дүгнэлт**

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг тооцож, үнэлэн дараах дүгнэлтийг хийлээ.

- 2023 онд санхүүжилт нь шийдвэрлэгдсэн зорилт, арга хэмжээнүүд төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байна.
- Нийт зорилтын 44.1 хувь, арга хэмжээний 51.9 хувь нь үр дүнтэй болон тодорхой үр дүнд хүрсэн байна.
- Зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэр нь тодорхойгүй болон энэ оны төсөвт тусгагдаагүйгээс шалгаалж зарим ажлууд удааширсан байна. Тухайлбал дээрх хэрэгжилт нь удаашралтай арга хэмжээнүүдээс 7 нь оны сүүлийн хагаст хэрэгжих, 18 нь төсөв хөрөнгөгүй, 4 арга хэмжээ нь удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ аваагүй, бусад байгууллагын шийдвэр гараагүй зэргээс хамаарчээ.

## **Дөрөв. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ /Зөвлөмж/**

- Хөтөлбөрийн 2023 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг жигд ханган зохион байгуулж, явцын болон гүйцэтгэлийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж, үр дүнг тооцох
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгө санхүүг жил бүрийн улс, орон нутгийн төсөвт тусгах
- Сумын Засаг даргын Тамгын газар, хэлтэс, агентлаг, байгууллагууд үйл явцыг бус гүйцэтгэл, үр дүн, хүрсэн түвшний талаар тайлагнаж, тухайн зорилт, арга хэмжээ зорилтот түвшиндээ хүрсэн эсэх, хүрээгүй бол шалтгаан нөхцөлийг тусгаж тайлагнах
- Сум, байгууллагын түвшинд хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний талаар мэдээлэл өгч, нэгдсэн ойлголтод хүрэх, харилцан уялдаатай нягт хамтран ажиллах

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС